

ТАНИН МЭДЭХҮЙД “УГТВАР ОЙЛГОХУЙН” ҮҮРГИЙН ТУХАЙ Г.ГАДАМЕРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Б.Дуламсүрэн - БХИС-ийн багш, Докторант

Түлхүүр үг: Ойлгохуй, өөрийн ухамсар, “сэжиг таамаг”, туршлага, үнэн, *pronesis* ба *techne*, хэл ба уламжлал

Товч утга: оюун сэтгэхүйн тухай шинжлэх ухаан нь байгалийн хуулиудыг судлахад хэрэглэгддэгээс эрс өөр танин мэдэхүйгээр урьдчилан тодорхойлогддог гэдгийг харуулж урьдач санаа бодол бол ойлгох нөхцөл мөн гэж үздэг чухам энэ үзэлд л герменевтикийн шийдэх асуудлын эх сурвалж хоргодож байдаг гэж Г.Гадамер дүгнэжээ.

“Үнэн ба арга” зохиолдоо Г.Гадамер урлагийн бүтээлийн мөн чанар, герменевтик туршлагын түүхэн шинжийг судалснаараа герменевтикийн хүрээг өргөжүүлж, герменевтик бол ертөнц дэх хүний ахуйн тулгуур асуудлуудыг авч үздэг болохоос түүхэн бичвэрүүдийг судлахад хэрэглэдэг арга төдийхөн биш гэдгийг харуулахыг зорьсон байна. Г.Гадамерын хувьд Хайдеггериинхтай адил ойлгохуй бол хүний үйл ажиллагааны өвөрмөц нэг төрөл биш, харин хүний ахуйг бүхэлд нь илэрхийлэх арга юм. “Ойлгохуй бол хүний өөрийнх нь амьдралын ахуйн эхний арга мөн” гэж тэрээр үзжээ¹.

Г.Гадамерын герменевтик дэх ойлгохуйн үйл явцын агуулга нь арга зүйн баримжаалалтай шинжлэх ухааны мэдлэг болоод амьдралаас тасархай философийн рефлекс гэдгээр ч зогсохгүй юм.

Й.П.Фон Вартенбургийн² адил Г.Гадамер ухамсрын үр дүнг гарал үүслийг нь илрүүлэх замаар шинжлэх зорилт тавьжээ. Дильтей, Гуссерлийн адил амьдралыг онол-танин мэдэхүйн талаас нь биш, Гегелийн үзэл баримтлалыг дэмжиж амьдрал ба өөрийн ухамсрын метафизик холбоог шинжилсэнд Вартенбургийн гавьяа оршино гэж Г.Гадамер үзжээ.

Амьдралын хүрээнд хамаарах бүх зүйл тухайн хүрээнд гаднаас биш, харин интериоризацийн (*interior*-лат. дотоод-нийгмийн гадаад үйл ажиллагааны бүтцийг эзэмших замаар хүний сэтгэцийн дотоод бүтэц төлөвших) явцад нэвтэрдгийнхээ хэрээр өвөрмөц юм гэж Г.Гадамер баталж байна. Интериоризацийн утга учрыг Гегелийн өөрийн ухамсрын үзэл баримтлалын жишээн дээр нээн гаргаж болно. “Түүний (өөрийн ухамсрын) оршихуй нь тэрээр бүх зүйлийг өөрийн мэдлэгийн зүйл болгон хувиргадаг чадварт, мөн тэр үед бүх мэдэж буй зүйлд, өөрийгөө мэдэж буйд оршино. Мэдлэг болохын хувьд өөрөөсөө өөрийгөө ялгах чадвар болж, өөрийн ухамсар нь өөртэйгөө нэгдэх замаар өөрийн хүрээ хязгаараас гарах гарц болдог”³.

Мэдлэгийг өөрийн ухамсрын модус гэж шинжлэх Гегелийн баримтлалыг үргэлжлүүлж Г.Гадамер өөрийн ухамсар хамгийн гол нь хэлний уламжлалд хандах хүний харилцаагаар урьдчилан тодорхойлогдоно гэж үзэж байв. Хэдийгээр ойлгохуй бол ертөнц дэх хүний ахуйн эхний бөгөөд үндсэн арга боловч ойлгохуйн урьдчилсан нөхцөл нь хэлэнд байна гэж тэрээр үзсэн юм.

Хэлний ойлголт нь туршлагын адил Г.Гадамерын герменевтикийн түлхүүр ухагдахуунд тооцогдоно. Г.Гадамерын бодлоор хэлний өвөрмөц мөн чанар нь хэл бол рефлексийн буюу өөрийн ухамсрын зэвсэг болдоггүйд оршино. "...үг бүрэлдэж байхад ямар ч рефлексив үйл явц үйлчлэхгүй, учир нь үг бол сэтгэхүйг биш, харин ойлгогдож буй объектыг илэрхийлнэ"⁴.

Үүний эсрэг философийн болон шинжлэх ухааны сэтгэхүй бол утга нь дангаараа мэт, утгат эхээс салангид ойлгогдох үг болон ойлголтуудыг ашигладаг: "философийн хэлэнд хэрэглэгдэж, утга нь тодотгогдож байдаг үгсийг ямагт "объект-хэлний" утгын талаас ойлгож, тэр хэрээрээ өөртэйгөө зохилдохгүй болдог". Логик агуулгыг нэг утгатайгаар төгс илэрхийлэхийг зорьдог байгалийн шинжлэлийн ойлголтуудаас ялгаатай нь ердийн хэлнээс зээлдсэн ойлголтууд шинжлэх ухааны өмнөх сэтгэлгээний баримжаатай байдгаас философи өөрийн хүрээнд огт өөр асуудлуудтай тулгардаг. Энэ тохиолдолд танин мэдэхүйн үйл явцад ч, харилцаанд ч хэлийг хэрэглэх нь хэлэнд тэмдэглэгдсэн тунамал утга нь "мэдлэгийн болон утгал мэдлэгийн эх сурвалж" болдог, өөрөөр хэлбэл тэдгээрийн утгыг илрүүлэх нь философийн судалгааны чухал зорилт болдог гэдгийг гэрчилж байна⁵.

Г.Гадамер "сэжиг таамаг" /предрассудок/ хэмээх ойлголтыг шинжлэх замаар ийм ухаарагдаагүй утгын мөн чанарыг нээхийг оролдсон байна. Шинэ үеийн философид энэ ойлголт анх философийн рефлексийн объект болон хувирсан юм гэж Г.Гадамер тэмдэглэжээ.

Соён гэгээрүүлэлтийн философийн чиг зорилт нь өөрийгөө ухамсарлагч оюун ухаанд хандаж нэр хүндэтнүүдийн /авторитетов/ оюун ухааны бие даасан байдлаас гарч ирдэггүй бүхнийг үгүйсгэдгээр тодорхойлогдож байв. Энэ утгаар соён гэгээрүүлэлт нь математикжсан платонизмын уламжлалаар бэлтгэгдсэн оюун ухааны хөдөлгөөн болдог ба тухайн байр сууринаас Г.Галилей аристотелийн шинжлэх ухааны үзэл санааг эсэргүүцэж байсан юм.

Философийн мэдлэг дэх сэжиг таамгийн эсрэг тэмцэл Ф.Бэкон, Р.Декартын үед бүр ч хурцаар илэрч байв. Танин мэдэхүйн үйл ажиллагаанд сэжиг таамаг болон буруу төсөөллөөс /идол/ татгалзахыг уриалахдаа Ф.Бекон гадны ямар ч хүчин зүйлтэй холилдоогүй цэвэр мэдлэгийн санааг /идеал/ удирдлага болгож байв. "Афоризм"-даа тэрээр "урьдач төсөөлөл" хэмээх ойлголтыг хэрэглэсэн нь Г.Гадамерын "сэжиг таамаг"-тай тодорхой хэмжээгээр төстэй юм. Гэхдээ Ф.Бекон байгалийг урьдчилан танин мэдэхийг "яарсан, боловсроогүй" хэрэг гэж нэрлэжээ⁶.

Танин мэдэхүйн үйл явцыг аливаа төрлийн урьдач нөхцөл, түүний дотроос уламжлалаар дамжсан сэжиг таамгаас хамгаалах санаа Р.Декартын "Аргын тухай эргэцүүлэл"-д бүр ч тодорхой байдаг. Арга зүйн өвөрмөц чиглэл бүрэлддэг өмнөх уламжлалыг шүүмжилснээр Р.Декартын эргэлзэх зарчим хэрэгждэг. Уламжлалын үндсэн шаардлагыг Р.Декарт үнэн юмыг итгэл үнэмшил гэж хүлээн авах боломжгүй, урьдач төсөөлөл, сэжиг таамгийг нэг бүрчлэн

зайлуулж зөвхөн эргэлзээнд өртөхөөргүй үнэн магадтай зүйлийг бодомжинд оруулах явдал гэж үзсэн юм.

Дээр өгүүлснээс үзвэл, Г.Гадамерын герменевтикийн чиг зорилт нь Р.Декартын рационализмаас урган гарч буй үндэслэлүүдийн эсрэг юм гэж дүгнэж болно.

Шинжлэх ухааны талаарх Г.Гадамерын шүүмжлэл нь хэрэг дээрээ Э.Гуссерлийн "Европын шинжлэх ухааны хямрал ба трансценденталь феноменологи"-д болон М.Хайдеггерийн дэвшүүлсэн шинжлэх ухааны мөн чанарыг тодорхойлсон санааг *techné* хэмээх феномений үүднээс сэргээж буй хэрэг юм. Тэр тусмаа Г.Гадамер шинжлэх ухаан техникийн хөгжил нь орчин үеийн нийгмийн муу муухай бүхний эх булаг гэж үздэг антисциентизмын төлөөлөгчдийн тэргүүнд байв. Г.Гадамерын герменевтикийн тулгуур утга нь орчин үеийн өрнөдийн соёлын үнэлэмжид улам гүнзгийрч буй хямралыг сэргэхэд нөлөөлөх туршлагын хэлбэр хэмээн шинжлэх ухааны нэр хүндийг бууруулах явдал байв.

Энэ асуудлыг Г.Гадамер: "шинжлэх ухаан хэрэг дээрээ үнэний цорын ганц тээгч, сүүлчийн шат мөн үү?" гэж томъёолоод, үүнд хариулахдаа хүн төрөлхтөнд байнга тулгарч байдаг амьдралын асуудлуудыг утгагүйд тооцон үл ойшоодгоороо шинжлэх ухаан дутагдалтай гэжээ.

Гэвч энэ нь шинжлэх ухааны өөрийн мөн чанарт хэр хамааралтай вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ. Европын шинжлэх ухааны хувьслыг эртний Грек дэх үүслийн үеэс нь шинжилж үзээд Гадамер анхны хэлбэрээрээ орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгээс ихээхэн ялгаатай байсныг тэмдэглэсэн байна. Грекчүүдийн хувьд чухамдаа шинжлэх ухааны үлгэр жишээ нь математик байв. Шинжлэх ухааны судлагдахуун нь дедуктив мэдлэгийн хэлбэрээр дамжин илэрхийлэгддэг цэвэр оюун ухааны ахуй юм. Мэдлэг дамжуулах цорын ганц арга нь /үнэнийг оруулаад/ өгүүлэмж буюу бодомж болж байв.

Аристотелийн логикийн үүднээс бодомжийн үнэн нь бодомжийн агуулга ба учир зүйн нийцлээс гарч ирдэг /*adaequatio intellectus ad rem*/. Судлагдахууныхаа оршихуйн өвөрмөц аргаар биш харин бүр илүү төгс мэдлэг байхын төлөө өрсөлддөгөөр математик нь үлгэр жишээ шинжлэх ухаан байдагт Шинэ үеэс эхлэлтэй орчин үеийн шинжлэх ухааны онцлог оршино гэж Г.Гадамер үзжээ. "Шинэ үеийн шинжлэх ухаан нь грекийн болон христийн европын мэдлэгийн хэлбэрүүдээс эрс шийдвэртэй салжээ. Одоо үед аргын тухай үзэл санаа ноёлж байна. Гэхдээ арга нь янз бүрийн шинжлэх ухаанд олон янзын хэлбэртэй ч орчин үеийн ойлголтоор нэг л юм. Аргын ойлголтын хүчээр тодорхойлогдох танин мэдэхүйн идеал нь ямагт дахин давтах боломжтой байдаг танин мэдэхүйн замыг хэр ухамсартай дагаж мөрдөхөд оршино... Аль хэдийн туулж өнгөрсөн замыг ямагт давтах чадвар нь аргыг тодорхойлж шинжлэх ухааны шинж болно"⁷.

Орчин үеийн шинжлэх ухаан дахь ийм төрлийн "методологизмын" үр дүн нь үнэнийг илэрхийлэхийн төлөө өрсөлддөг хүний мэдлэгийн хүрээг хязгаарлах

болсон гэж Г.Гадамер баталж байна. Р.Декартын томъёолсонтой холбоотойгоор шинжлэх ухааны идеал нь танин мэдэхүй үнэний биш харин баттай магадтайн шалгуурт нийцэж байх ёстой. Үүнтэй холбоотойгоор Г.Гадамер шинжлэх ухааны мэдлэгээр өөрийгөө хязгаарладаггүй туршлагыг өргөжүүлэх зорилт дэвшүүлж энэ туршлага нь оюун сэтгэхүйн хямралын зуунд хүнд шинэ шинэ амьдрах хүч өгөх чадвартай гэж тэрээр үзжээ. Шинжлэх ухааны мэдлэгийн тэр хүрээг давах боломжтой юу? ямар утгаар, ямар аргаар давах вэ? гэдэг асуулт философийн өмнө тавигдах ёстой гэж Г.Гадамер бичжээ.

Онолын баталгаагүйгээр ямарваа нөхцөл байдлын үнэнд итгэх боломж олдог практик амьдралын туршлагыг Г.Гадамер мэдлэг олж авах шинжлэх ухааны гадуурх хүрээний нэг гэж нэрлэсэн юм. Энэ тохиолдолд хэлний логик дүрмүүдэд захирагдсан субъектив мөн чанараас урган гардаг өгүүлэмжийн логик хэлбэрийн хязгаарлагдмал явцуу байдлыг хэл болон харилцааны янз бүрийн хэлбэрүүд өөрсдөө харуулдаг байна. “Объектив танин мэдэхүйн явцад субъектив туршлагын тохиолдлыг даван туулах”, эцсийн бүлэгт “олон утгат тэмдгийн хэлийг ойлголтын нэг утгаар” солих чиглэлтэй шинжлэх ухааны философийн позитивист хандлагыг тэрээр огт ирээдүйгүй оролдлого гэж дүгнээд Г.Гадамер харилцааны хэлийг онцгой статустай гэж үзэв. Энэ хэл нь “өгүүлэмжүүдийн ердийн нийлбэр” биш, харин “аливаа дараалсан логик анализын утга төгөлдөр өгөгдөхүүн” гэж тэрээр тэмдэглэжээ. Гэхдээ арга зүйн баримжаатай шинжлэх ухаанууд туйлын тодорхой, нотлогдсон мэдлэгт эрмэлзэж байхад “оюун сэтгэхүйн шинжлэх ухаанууд” голдуу асуудалтай, аливаа боломжийн арга хэрэглэн хамгийн доод түвшинд анализ хийж болмоор, мөн логик өгүүлэмжийн хэлбэрээр илэрхийлэхээр асуудлуудтай тулгарч байдаг. Г.Гадамерын үзлээр туршлагын шалгуур огт боломжгүй тэр хүрээнд л “оюун сэтгэхүйн шинжлэх ухаанууд” үлэмж үр дүнтэй амжилт олж чадах юм.

“Оюун сэтгэхүйн шинжлэх ухаанууд” дахь арга зүйн үүргийг үгүйсгэхдээ Г.Гадамер XIX зууны герменевтикийн уламжлалыг төдийгүй ялангуяа арга зүй нь шинжлэх ухааны мэдлэгийг амжилтанд хүргэх ёстой Дильтейн “оюун сэтгэхүйн шинжлэх ухааныг” үндэслэсэн төслийг сөрөн зогссон юм. Эцсийн дүндээ Г.Гадамер шинжлэх ухаанд үнэн мэдлэг ер нь боломжгүй гэж үзсэн байна. “Үнэн гэж юу вэ?” өгүүлэлдээ тэрээр үнэнийг илэрхийлэх гэж эрмэлзэж буй өгүүлэмжийг логик анализаас огт өөр нөхцлөөр хангах ёстой гэж тэмдэглэжээ. Бүр тодруулбал: “Туйлын үнэн өгүүлэмж гэж байхгүй гэж бүрэн хариуцлагатайгаар мэдэгдэж болно гэж би үзэж байна” гэжээ.

Г.Гадамерын энэ хурцаар илэрхийлсэн релятивист шинжтэй нотолгоо нь шинжлэх ухааны мэдлэгийг үнэлэхэд чиглэсэн түүний философийн зорилтын логик үр дагавар болж байна. Чухам иймээс Г.Гадамер герменевтикийн сонгодог үеийн шинж болсон байгалийн шинжлэл болон “оюун сэтгэхүйн шинжлэх ухаан”-ы хоорондох дихотомийг сэргээх хэрэгтэй болсон бөгөөд үүний хор холбогдлыг Дильтей хожим ойлгожээ.

“Оюун сэтгэхүйн шинжлэх ухаанууд”-ыг байгалийн шинжлэл болон онолын мэдлэгт сэргүүлэн тавих Г.Гадамерын үндсэн сэдэл нь “оюун сэтгэхүйн шинжлэх ухаанууд”-ад өвөрмөц маягаар тайлбарлагддаг “практик хэмжигдэхүүн” байгааг хүлээн зөвшөөрсөнд оршиж байна. Герменевтикийн хүрээнд түүний авч үздэг асуудлуудын онцлог нь Аристотелийн судалгаатай, ялангуяа “Никомахын ёс зүйн” 6-р номонд боловсруулсан асуудлуудтай нягт холбоотой гэдгийг Г.Гадамер нэг бус удаа тэмдэглэсэн байдаг. Аристотель герменевтиктэй тулгарч байгаагүй ч “Хэрэв бид эцсийн дүндээ ёс зүйн феномены Аристотелийн тодорхойлолтыг, ялангуяа ёс суртахууны мэдлэгийн чанарын ойлголтыг бидний судалгаатай нэгтгэх юм бол хэрэг дээрээ Аристотелийн судалгаа нь герменевтик танин мэдэхүйн нэг загвар болох нь мэдэгдэнэ”⁸.

“Никомахын ёс зүй”-д туссан Аристотелийн судалгаа юугаараа Г.Гадамерыг татав, герменевтик танин мэдэхүйн нэг загвар болоод зогсохгүй Г.Гадамерын герменевтик философийн онцлогийг бүхэлд нь тодорхойлж буйгаараа юу?

Г.Гадамерын бодлоор Аристотель сократ – платоны сайн үйлийн үзлийн ойлголт дахь интеллектуализмыг шүүмжилснээрээ метафизикээс хараат бус ёс зүйг үндэслэгч болсон юм. Тэрээр Платоны сайны үзэл нь гүехэн утгатай ерөнхий үзэл гэдгийг харуулахыг оролдож түүнд хүн төрөлхтний сайн үйлийн үзлийг сэргүүлэн тавьж, өөрөөр хэлбэл хүн төрөлхтний үйл ажиллагаатай харьцуулсан сайн үйлийг эсрэгцүүлсэн юм. Тэр тусмаа Аристотель Платоны сайн үйл (arete) ба мэдлэгийг (logos) адилтгасан сургаалын зөрүүтэйг харуулсан байна. Аристотелийн онолоор сайн үйлийн үндэс нь практик ба зан төрх (ethos) байдаг бөгөөд ёс зүй нь шинжлэх ухаан болохын хувьд аль эртнээс үүнийг гэрчилж байдаг.

Аристотелийнхоор ёс суртахууны зан төрх нь байгалийн хуулиар тогтоогдсон хүчний үйлчлэлийн үр дүн биш, харин гадны хүчний шинж чанараас огт гараагүй хүний тодорхой үйлдлүүдийг өөрөө хэрэгжүүлсний үр дүн байдгаараа байгалийн ахуйгаас ялгаатай гэж Г.Гадамер үзэж байна. Хүний ёс суртахууны ахуйд тийм төрлийн мэдлэгийн үүргийн тухай асуулт гарч ирнэ.

Үүнд хариулж Г.Гадамер: “сайны тухай Платоны сургаалын эсрэг Аристотель ёс зүйн салбарт математик мэдлэгийн нарийн тогтсон байдлыг хэрэгжүүлж яагаад ч болохгүй, учир нь хүний байнга оршдог нөхцөл бол хууль бус тохиолдлууд нь бидний жинхэнэ зорилгыг л улам төвөгтэй болгож байдаг гэж эрс шийдэмгий онцолсон байдаг... Хэрэг дээрээ ёс зүйн феномены хувьд агент нь ямар шийдвэр гаргах болон юуг дагаж мөрдөхөө хамгийн ерөнхий байдлаар төсөөлөөд зогсохгүй тухайн нөхцөлд биеэ хэрхэн авч явах, гарцаагүй хариуцлагаа мэдэж ойлгож байх ёстой нь маш чухал. Тиймээс ёс зүйн шинжлэх ухаан нь ёс зүйн ухамсрын асуудлыг тодорхойлоход тусалдаг ч ёс зүйн тодорхой ухамсрын байр суурийг хэзээ ч эзлэхгүй”.

Үүнтэй холбоотойгоор Г.Гадамер Аристотелийн *phronesis* гэж тэмдэглэсэн ёс зүйн мэдлэг – чадварыг *episteme* болон *techné* – гээс ялгаж үзсэнд онцгой анхаарсан байна.

Episteme бол шинжлэх ухааны мэдлэг, түгээмэл мэдлэг, суралцаж болох онол тул *phronesis* болон *techné* – д сөргүүлэн тавихад онцгой эргэлзээ төрүүлэхгүй юм. *Techné* бол эн түрүүнд техникийн мэдлэг – чадвар бөгөөд ёс зүйн мэдлэг – чадвар *phronesis*-той тун адилхан. Тэдгээрийн нийтлэг шинжийг бүр Сократ, Платон нар тэмдэглэж байв. Энэ адилсал нь “аль нь ч абстракт мэдлэгийн төрөл биш бөгөөд эсрэгээр тодорхой чанар, үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөгөөрөө хоёулаа тодорхой зорилтыг шийдвэрлэхэд практик ач холбогдолтой” байдагт оршино⁹.

Мөн тэр үед Аристотель, түүний дараа Г.Гадамер *pronesis* ба *techné* – гийн хоорондын ялгааг гаргах нь онцгой чухал гэж үзсэн юм. Уг ялгааг тэмдэглэсэн гурван зүйлийг гаргасан байна. Үүнд:

Нэгдүгээрт, техникийн мэдлэгт (*techné*) суралцаж болно, бас түүнээс зайлсхийж болно. Энэ нь харин ёс суртахууны мэдлэгийн хувьд боломжгүй. Ёс суртахууны мэдлэгийг эзэмшиж болно, болохгүй гэсэн юм байхгүй. Хүн бол ямагт үйлдлийн орчинд байж, ёс суртахууны мэдлэгийг эзэмшиж ашиглаж байх ёстой байдаг. Ёс суртахууны мэдлэгийг хэрэглэх нь өвөрмөц онцлогтойг тэмдэглэж Г.Гадамер: “...ёс суртахууны мэдлэгийг ямар нэг байдлаар аяндаа эзэмшиж байдаг биш, харин дараа тодорхой нөхцөлд ашиглахаар олж авч байдаг”. Энэ мэдлэг зан үйлийн тодорхой нөхцлөөс хараат бишээр оршдоггүй, харин зан үйлэнд хэрэгжиж байдаг.

Хоёрдугаарт, ёс суртахууны мэдлэг нь зорилго болон арга хэрэгслийн хоорондын өвөрмөц харилцаагаар техникийн мэдлэгээс ялгаатай. Ёс суртахууны мэдлэгийн зорилго нь ямар нэг тодорхой зүйл биш, “насан туршийн амьдралын ёс суртахууны нэгдмэл зарчмыг урьдчилан тодорхойлдог”. Техникийн үйл ажиллагаа нь зорилгод хүрсэн арга хэрэгслээ тухай бүр шалган нягтлахыг шаарддаггүй бол ёс суртахууны хувьд энэ нь чухал байдаг. Тэр тусмаа “ямар ч тохиолдолд ёс суртахууны ухамсар нь бүх баримтуудыг урьдчилан мэдээгүй байсан ч хувийн шийдвэрээ хариуцах ёстой болдог”. Өөрөөр хэлбэл ёс суртахууны үйлдлийн хүрээнд зорилгод хүрэх арга хэрэгслийн талаар урьдчилсан мэдлэг байдаггүй, учир нь юуны өмнө тэр зорилго нь нарийн тодорхойлогддоггүй юм. Үүний үр дүнд “ёс суртахууны мэдлэг нь туршлагын гол хэлбэр болдог учраас тухайн тохиолдолд мэдлэг ба туршлагын ялгааг гаргах нь утгагүй байдаг” ёс суртахууны мэдлэгийн өвөрмөц онцлог оршино гэж Г.Гадамер дүгнэжээ.

Гуравдугаарт, ёс суртахууны рефлекс нь ойлгохуй (*synesis*) хэмээх өвөрмөц элементийг агуулдаг бөгөөд түүгээр дамжуулан ёс суртахуун нь бусад хүмүүсийн үйлдэлтэй харьцаж байдаг. “Бусадтай харилцахад хүрдэг нөхцөл байдлыг сэтгэхүйн хувьд бүрэн дүүрэн тодорхой болгож болдог бол ойлгохуйн

тухай яригдана гэдэг нь бүр ч илэрхий байна. Энэ тохиолдолд бид ерөнхий шинжтэй мэдлэгийн тухай биш тодорхой зүйлийг л авч үзнэ. Мөн энэ мэдлэг нь ямар нэг утгаар техникийн мэдлэг, түүнийг хэрэглэх тухай биш юм” гэж Г.Гадамер бичжээ.

Pronesis ба episteme, techne – гийн ялгааны тухай Аристотелийн судалгаа нь герменевтикийн хувьд ямар үүрэгтэйн тухай асуулт зүй ёсоор гарч ирнэ. Г.Гадамерын үзлээр, ийм төрлийн судалгаа нь “оюун сэтгэхүйн шинжлэх ухаануудын” авч үздэг асуудлуудын өвөрмөц онцлогийг тайлбарлаад зогсохгүй тэдгээрийг шийдвэрлэх тухай ч авч үздэг. Хэдийгээр Аристотель тодорхой хэмжээгээр Сократ – Платоны уламжлалын нөлөөнд байгаа ч түүний хувьд мэдлэг нь урьдын адил ёс зүйн зан үйлийн гол зүйл хэвээр байгаа учраас “Аристотелийн тодорхойлж буйгаар ёс суртахууны мэдлэг нь юмсын мэдлэг биш, өөрөөр хэлбэл энэ мэдлэгийг тээгч нь тэмдэглэсэн мэдлэгийн агуулгад эсрэг төдийгүй танин мэдэж байгаа зүйлдээ шууд нөлөө үзүүлдэг. Энэ мэдлэг нь тухайн юмтайгаа харилцан үйлчилдэг мэдлэг юм”.

Ёс суртахуун – практикийн мэдлэг – үйлдэл ба “оюун сэтгэхүйн шинжлэх ухааны” тулгардаг мэдлэгийн хооронд Г.Гадамерын гаргасан адилсалыг чухам ийм утгаар ойлгох хэрэгтэй болно. Г.Гадамер: “герменевтик мэдлэг нь танин мэдэхүйн объектив шинжийг хэрэгсэхгүй байх ёстой”, энэ нь идеалчлагдсан, хувиршгүй ахуйг математикаас зээлдсэн аргын тусламжтайгаар ойлгоход чиглэгдсэн грек идеалаас гаралтай онолын мэдлэг – epistemийн шинж гэж үзэж байна.

Г.Гадамер объектив шинжтэй шинжлэх ухааны мэдлэг болох зорилтын ул мөр XIX зууны герменевтикт, ялангуяа “орчин үеийн шинжлэх ухааны объективч аргын түрэмгий нөлөө” бүхий Дильтейн “оюун сэтгэхүйн тухай шинжлэх ухааны” арга зүйд байгааг олж харсан байна. Ийм онолын шинжлэх ухааны эсрэг “оюун сэтгэхүйн тухай шинжлэх ухаанууд” нь ёс суртахууны мэдлэгтэй маш нягт холбоотой гэж Г.Гадамер онцлон тэмдэглэж байна.

Тийм учраас “оюун сэтгэхүйн тухай шинжлэх ухаанууд” гэдэг нэр томъёоны англи эквивалент – moral sciences нь эдгээр шинжлэх ухааны авч үздэг мэдлэгийн мөн чанарыг ихээхэн хэмжээгээр илэрхийлдэг. Герменевтикийн хүрээнд онцолсон ёс суртахууны мэдлэгийг герменевтик ухамсраар хязгаарлагдсан мэтээр авч үзэхгүй байхыг Г.Гадамер бас сануулж байна. Герменевтик нь ёс суртахууны мэдлэгийн адил юуны өмнө мэдлэгийг эзэмших болон ашиглах асуудлыг шийдвэрлэдэг тухай ярьж байна гэж тэрээр бичжээ. “Хэрэглээ бол ойлгохуйн феномены нэмэлт болон тохиолдлын хэсэг нь биш харин бүр эхнээсээ л энэ феномены шинжийг бүхэлд нь тодорхойлдог. Хэрэглээ бол тодорхой нөхцөлд урьдчилсан өгөгдөл болдог ямар нэг ерөнхийн дэлгэрүүлэлт биш юм. Тайлбарлагч уламжлалтай тулгарахдаа түүнийг өөртэйгөө харьцуулан хэрэглэхийг эрмэлздэг. Гэхдээ уламжлалаар дамжсан бичвэр түүний хувьд ерөнхий болж ямар нэг байдлаар ойлгогдоно гэх биш, харин бүр дараа нь хэрэглэгдэнэ. Эсрэгээр тайлбарлагч энэ ерөнхий – бичвэрийг, өөрөөр хэлбэл уламжлалын өгүүлж буйг, бичвэрийн утга агуулгыг

ойлгохоос өөр зүйлд эрмэлздэггүй. Гэхдээ үүнийг ойлгохын тулд тайлбарлагч өөрийгөө болон оршиж буй герменевтик нөхцлөө үгүйсгэх хэрэггүй. Ер нь ойлгохыг хүсч байгаа бол бичвэрийг нөхцөл байдалтай харьцуулах ёстой” гэдгийг герменевтик асуудал харуулж байна гэж Г.Гадамер бичжээ.

Ийнхүү Г.Гадамерын герменевтик нь хүний ойлгохуй хэрэгждэг жинхэнэ нөхцөл бол ямагт герменевтик сэтгэлгээний төвд оршдог хэл ба уламжлал – ойлголтуудаар дамждаг нөхцөл юм гэдэгт гол анхаарлаа хандуулсан байна.

Summary

The concept of phronesis can itself be seen as providing a certain elaboration of the dialogic conception of understanding G.Gadamer had already found in Aristotle, and, taken together, these two concepts can be seen as providing the essential starting point for the development of G.Gadamer's philosophical hermeneutics.

Тайлбар:

1. Х.Г.Гадамер.Истина и метод.М.,1988. х.41
2. Германы хуульч, түүхч, философич
3. Х.Г.Гадамер.Истина и метод.М.,1988. х.239
4. Мөн тэнд х.366
5. Мөн тэнд х.524
6. Х.Г.Гадамер.Актуальность прекрасного.М.,1991. х.16
7. Мөн тэнд х.50
8. Х.Г.Гадамер.Истина и метод.М.,1988. х.307
9. Мөн тэнд х.54